

“Хөх ган” ХХК-ийн нийтэд санал болгон
гаргаж буй хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7 дахь заалт, “Хөх ган” компанийн хувьцаа эзэмшигчдийн 2008 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Хөх ган” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 101.317.557 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн бүртгэл, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Х. Бум-Эрдэнэ/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Хөх ган” ХХК-ийн нийт хувьцааны 75 хувийг эзэмшигч “Бэрэн групп” ХХК-ийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа нээлттэй ХК-ийн 53.191.714 ширхэг, 25 хувийг эзэмшигч “Фабер инвестмент” ХХК-ийн эзэмшилд байгаа хаалттай компанийн хувьцаа нээлттэй ХК-ийн 17.730.571 ширхэг хувьцаа болон хөрвөсөн тул өмчлөх эрхийг баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д зөвшөөрсүгэй.

3. “Хөх ган” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 30.395.272 ширхэг хувьцааг нийтэд санал болгон Хөрөнгийн биржээр арилжаалахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

4. Үнэт цаас гаргагч “Хөх ган” компани, андеррайтерийн “БиДиСек” ХК-ийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу анхдагч зах зээлд гаргаж байгаа хувьцаанаас 20 сая ширхэг хувьцааг багцаар нь “БиДиСек” ХК-д Хөрөнгийн биржийн арилжаагаар 100 төгрөгийн нэрлэсэн үнээр арилжихыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын хавсралтаар баталсан товч танилцуулгын дагуу үнэт цаасыг нийтэд сурталчлан, олон нийтийг бодитой мэдээллээр хангах, Хорооноос зөвшөөрсөн үед арилжааг эхлүүлэхийг “БиДиСек” ХК /Д.Даянбилгүүн/, үнэт цаасны арилжааны тайланг хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг ханган, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Хөх ган” ХХК /Б.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.

6. ХК болон өөрчлөгдсөн тухайгаа Улсын бүртгэлийн албанд ажлын 5 хоногийн дотор мэдэгдэж, бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Хөх ган” ХХК /Б.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.

7. Хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор баталсан “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан дотоод журмуудыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг “Хөх ган” ХХК /Б.Мөнхтөр/-д үүрэг болгосугай.

8. Энэхүү тогтоол болон хавсралтыг ажлын 3 хоногийн дотор Хорооны веб хуудсанд байршуулахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г тус тус даалгасугай.

ДАРГА
Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

ХӨХ ГАН ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА

Танилцуулгын эхний хэсэг

1. Үнэт цаас гаргагчийн түүх, үйл ажиллагааны төрөл, хэтийн төлөв, үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн чиглэл

“Хөх ган” ХХК нь МУ-ын Бэрэн групп ХХК, Сингапур улсын Фабер инвестмент ХХК-ний хамтарсан хөрөнгө оруулалтаар Монгол улсад анхны ангижруулсан төмрийн үйлдвэрийг бариж ашиглалтанд оруулахаар 2007 онд байгуулагдсан. “Хөх ган” ХХК нь 2007 оноос ангижруулсан төмөрлөгийн үйлдвэрийг барих төслийг хэрэгжүүлж эхэлсэн. “Хөх ган” ХК нь үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Төмөрлөгийн үйлдвэрлэл, гадаад худалдаа билээ.


Энэхүү төслийн зорилго нь жилд 30,000 тонн ангижруулсан төмөр үйлдвэрлэх хүчин чадалтай ангижруулсан төмөрлөгийн үйлдвэрийг Эрдэнэт хотын Говиль багын нутагт барьж байгуулахад оршино.

Төсөл хэрэгжүүлэлтийг дараахь ерөнхий хуваарийн дагуу гүйцэтгэн явуулна.

- Үйлдвэрийн эхний 15,000 тонны хүчин чадалтай шугамыг 2008 оны 6 сард дуусгаж үйл ажиллагааг эхлэх
- Үйлдвэрийн хоёрдугаар 15,000 тонны хүчин чадалтай шугамыг 2008 оны 10 сард дуусгаж үйл ажиллагааг эхлэх
- 2008 онын 12 сарын 1-нээс бүрэн хүчин чадлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Энэхүү үйлдвэр баригдсанаар орчин үеийн технологиор төмрийн баяжмалыг боловсруулж, сайн чанарын ган үйлдвэрлэх шаардлагад тохирох бүтээгдэхүүн гаргах ба ингэснээр эхний ээлжинд уг бүтээгдэхүүнээ экспортлох, цаашидаа Монгол улсад төмөрлөгийн болон гангийн үйлдвэрлэлийг гадны хамгийн сүүлийн үеийн шинэ технологи нэвтрүүлэх замаар дэлхийн хөгжиллийн чиг хандлагыг амдан хөгжүүлэхэд чиглэн ажиллаж дотоодын үйлдвэрлэлийн салбарын төмөр болон ган бүтээгдэхүүний эрэлтийг хангах, мөн гадаадын өсч буй эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой болох юм.

2. Үнэт цаас гаргагчийн удирдлага зохион байгуулалын бүтэц,



3. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах тухай үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагын шийдвэр.

Хөх ган ХХК –ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2008 оны 3 сарын 07- ны өдрийн 03/08 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2008 оны 3 сарын 07- ны өдрийн 02/08 тогтоолыг тус тус үндэслэв.

4. Сангийн сайдын 2004 оны 12 сарын 22-ны өдрийн 248 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар”, Хорооноос баталсан “Үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын тайланд нэмэлт тодруулга бэлтгэх журам”-д заасан нэмэлт тайлбар тодруулгыг бүрэн тусгасан сүүлийн 3 жилийн болон үнэт цаасыг бүртгүүлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргахын өмнөх улиралын аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан:

Хөх ган ХХК-ийн 2007 оны жилийн эцсийн болон 2008 оны 1 дүгээр улирлын аудитын байгууллагаар баталгаажсан тайлангуудыг хавсаргав.

5. Үнэт цаас гаргагч компани болон түүний толгой, охин компани болон хяналтын багцыг эзэмшигчид, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд нь хугацаа хэтэрсэн

зээлийн өргүй болох талаар банкны өр барагдуулах алба, харилцагч банкны тодорхойлолт:

Хөх ган ХХК нь хугацаа хэтэрсэн зээлийн өргүй бөгөөд харилцагч банкны болон банкны өр барагдуулах албаны тодорхойлолтыг хавсаргав.

Хяналтын багцыг эзэмшигч Бэрэн групп ХХК-ийн өр төлбөрийн талаарх банкны тодорхойлолтыг хавсаргав.

6. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэн баталгаажуулсан материал:

Ситико-Аудит ХХК-ийн УБГ дугаар 9011012054, 2112914 тоот регистрийн дугаартай.

Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн дугаар 13

2006.05.13 –ны өдрөөс 3 жилийн хугацаатай

Их тойруу-11 Өөрийн байранд, Улаанбаатар хот, Утас 70118318

Хөх ган ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан бизнесийн үнэлгээний тайланг хавсаргав.

7. Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамж төлсөн баримт:

Хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэх зөвшөөрлийн хураамжийг төлсөн баримтыг хавсаргав.

Танилцуулгын хоёрдахь хэсэг

1. Үнэт цаасны төрөл, хэлбэр:

- | | |
|-------------------------------|----------------|
| a. Үнэт цаасны төрөл: | Энгийн хувьцаа |
| b. Үнэт цаасны хэлбэр: | Биет бус |

2. Үнэт цаас эзэмшигчийн эрх:

МХБ-ээр дамжуулан энгийн хувьцааг худалдан авч өмчилсөн байгууллага, иргэн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 1) Хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр худалдах;*
- 2) Хувьцаагаа барьцаалах, бэлэглэх;*
- 3) Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмисэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.*
- 4) Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэх өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.*
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор ишидвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах,*
- 6) Компанийг татан буулгах үед “Компанийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.*
- 7) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.*
- 8) Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар ишидвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад*

оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

- a. Нийтлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
- b. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
- c. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- d. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
- e. Хувь нийлүүлэгч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.

3. Үнэт цаасыг анхдагч зах зээлд арилжаалах арга хэлбэр, график:

- a. Хөх ган ХК-ийн энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа МХБ болон ҮЦТТТХТ ХХК-тай хийсэн гэрээний дагуу үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгалах бөгөөд нийлүүлэлтийг ҮЦТТТХТ ХХК-д “Хөх ган” ХК-ийн данс нээлгэн уг данснаас андеррайтер “БиДиСЕК” ХК нь нийлүүлэлтийг 2 хувааж хийнэ.
- b. Үнэт цаас гаргагч “Хөх ган” компани, андеррайтер БиДиСЕК ХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын /firm commitment/ гэрээнд заасны дагуу анхдагч зах зээлд гаргаж байгаа 20 000 000 ширхэг хувьцааг тэргүүн ээлжинд “БиДиСЕК” ХК нь МХБ-ийн багцын арилжаагаар 100 төгрөгийн нэрлэсэн үнээр нийлүүлэлтийг хийж худалдан авах үүрэгтэй..
- c. Хөх ган ХК-ийн үлдэх энгийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээл дээр арилжаалахдаа 1 дансанд дээд тал нь 20 сая төгрөгийн хувьцаа худалдан авахаар хязгаарлалтыг хийж, анхдагч зах зээлийн арилжааны цаг болох 30 минутад захиалгыг төвлөрүүлэн 10 000 000 ширхэг хувьцааг үнийн ахлах дараалалаас 100 төгрөгийн үнэ хүртэл нийлүүлэлтийг хийнэ. Анхдагч зах зээл дээр бүрэн худалдагдахгүй бол арилжааны программд шивжс үлдээнэ.
- d. Үнэт цаасны арилжааны мэдээг: Харилцагч нар өөрийн харьяа брокер, дилерийн компаниуд болон хөрөнгө оруулалтын зөвлөх, Андеррайтер, Брокер, Дилерийн БиДиСЕК ХК-ийн www.bdsec.mn болон МХБ-ийн www.mse.mn сайтуудаас арилжааны мэдээллийг авч болно.

4. Урьд үнэт цаас гаргаж байсан эсэх, үнэт цаасны нэр төрөл, гаргасан огноо, нийт хэмжээ, төлөгдөх буюу төлөгдсөн хэмжээ, өрийн бичиг гаргасан бол үндсэн болон хүүгийн төлбөрийг хугацаанд нь барагдуулж байсан тухай үнэт цаасны төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт:

- а. Хөх ган ХХК нь урьд өмнө нь өрийн бичиг болон энгийн хувьцааг гаргаж байгаагүй болно.

5. Үнэт цаас гаргах замаар хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төсөл, эдийн засгийн үр ашгийн тооцоо:

- а. Үнэт цаас гаргаж хуримтлуулах хөрөнгөөр ангижруулсан төмөрлөгийн үйлдвэрийн 2 дугаар шугамыг байгуулахад ашиглана.

2 дугаар шугамд шаардлагатай хөрөнгө оруулалт

№	Зардлын төрөл	ам доллараар	төгрөгөөр
1	Тоног төхөөрөмж	1,350,548.00	1,580,141,160.00
2	Газан зуух	186,887.00	218,657,790.00
3	Татвар / Нөт/	238,302.42	278,813,831.40
4	Вагон /тээвэр/	64,827.59	75,848,280.30
5	Газар шорооны ажил	35,800.00	41,886,000.00
6	Барилгын ажил, барилгын материал	491,375.00	574,908,750.00
7	Суурь цутгах /цемент/	146,800.00	171,756,000.00
8	Суурийн ажлын зардал	45,000.00	52,650,000.00
9	Бусад	42,600.00	49,842,000.00
10	нийт өртөг	2,602,140.01	3,044,503,811.70
11	2-р шугамын өртөг	2,602,140.01	3,044,503,811.70

Эдийн засгийн үр ашгийн тооцоо /2008-2013 он/

Д/д	Үзүүлэлт	2008 он	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
1	Нийт орлого	4,000,000	9,600,000	9,600,000	9,600,000	9,600,000	9,600,000
2	Нийт зардал	2,370,005	5,972,215	5,972,215	5,972,215	5,972,215	5,972,215
4	Үйлдвэрлэлийн зардал	2,069,975	5,252,143	5,252,143	5,252,143	5,252,143	5,252,143
6	Тээврийн зардал	300,030	720,072	720,072	720,072	720,072	720,072
7	Татварын өмнөх ашиг	1,629,995	3,627,785	3,627,785	3,627,785	3,627,785	3,627,785
8	Татвар /НӨТ/	250,000	531,946	531,946	531,946	531,946	531,946
9	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	1,379,995	3,095,839	3,095,839	3,095,839	3,095,839	3,095,839
6	Хуримтлагдсан ашиг/алдагдал/	965,997	3,133,084	5,300,171	7,467,258	9,634,346	11,801,433
		Үнийн дүн	413,999	928,752	928,752	928,752	928,752
7	Ногдол ашиг хувиарлалт	Цэвэр ашигт эзлэх хувь хэмжээ	30	30	30	30	30
8	Нийт хувьцааны тоо ширхэг		101,317,557	101,317,557	101,317,557	101,317,557	101,317,557
9	Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг		4.78	10.73	10.73	10.73	10.73
10	EPS (MNT)		15.94	35.75	35.75	35.75	35.75

6. Үнэт цаасыг арилжаалахад санал болгох хүрээ:

- a. Дотоодын томоохон хөрөнгө оруулагч нар авах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.
- b. БиДиСЕК ХК-ийн хөрөнгө оруулагч нарт санал болгосон.
- c. Хувьцааны талаарх мэдээллийг Хөх ган ХК-ийн www.khukhgan.mn дээр байрлуулах, БиДиСЕК ХК болон МХБ-ийн сайт, өдөр тутмын сонингуудаар дамжуулан ард иргэд болон санхүүгийн байгууллагуудад, мэргэжлийн байгууллагуудад хүргэнэ.

7. Тухайн үнэт цаасыг худалдан авснаар хөрөнгө оруулагчид учирч болох эрсдэл, эрсдлийн шинжилгээ:

Хөх ган энгийн хувьцааг худалдаж авснаар хөрөнгө оруулагчид дараах зүйлүүд дээр анхаарч үзнэ үү.

Доор дурдсан эрсдлийн хүчин зүйлүүдээс хамааран компани төлөвлөсөн үр дүндээ хүрэхгүй байх магадлалтай. Эдгээрт:

- i. Монгол улсын эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал
- ii. Үйл ажиллагааны эрсдэл
- iii. Хууль эрх зүйн орчны өөрчлөлтүүд
- iv. Зах зээлийн эрсдэл
- v. Бусад эрсдэл

Зах зээлийн нөхцөлд бизнесийн орчны өөрчлөлтгүй хувьсамтгай байдал макро болон микро эдийн засгийн нөлөөлөлд аж ахуйн үйл ажиллагаагаа буруу тооцоолох, мөн инфляци эрсдэл, татварын эрсдэл, бүтээгдэхүүний үнэ ханшын бууралт гэх учирч болзошгүй эрсдэлийг үнэлж тооцох шаардлагатай.

Тус компанийн аж ахуйн үйл ажиллагаа явуулж байх тохиолдолд дараахи төрлийн эрсдэл учирч болох магадлалтай.

Үүнд:

- *Түли шатахууны үнийн өсөлт нь үйлдвэрийн үйл ажиллагааны зардлыг өсгөх магадлалтай.*
- *Техник тоног төхөөрөмжийн эвдрэл*
- *Компанийн зүгээс хүлээж болох гол эрсдэл нь түүхий эд ханшийн өсөлт*
- *Үйлдвэрлэлийн технологийн горимыг чанд мөрдөн ажиллахтай холбогдон үүснэ.*

Эдгээр эрсдлүүдийг багасгах зорилгоор доорхи үйл ажиллагааг авч явуулана.

Компанийн гол түүхий эд болох төмрийн хүдрийн баяжмалыг “Бэрэн групп” ХХК-аас авах ба түүхий эд худалдан авах гэрээг урьдчилсан байдлаар 2 жилийн хугацаатай байгуулсан билээ. “Бэрэн групп” ХХК-аас төмрийн хүдрийн баяжмал худалдан авахаар гэрээ байгуулснаар түүхий эдийн нөөцийн хомсдолд орох эрсдлийг багасгаж үйлдвэрийн үйл ажиллагаа олон жил тогтвортой жигд ажиллах бүрэн боломжтой болж байна.

/Бусад эрсдэл /давагдашгүй хүчин зүйлсийн эрсдэл: Байгалийн гэнэтийн үзэгдлүүд зэрэг хүчин зүйлс нь компанийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмжид гэмтэл, бэртэл, эрсдэл учруулах боломжтой ба үүнээс гарах эрсдэл, засвар зэрэгт зарцуулсан хөрөнгө нь компанийн санхүүгийн үзүүлэлтэнд муугаар нөлөөлөх талтай.

8. Үнэт цаасыг андеррайтераар дамжуулан анхдагч зах зээлд худалдахаар төлөвлөж байгаа бол байгуулах гэрээний төсөл, өөрөө анхдагч зах зээлд худалдах бол мэдээллийг нийтэд сурталчлах журам, төлөвлөгөө:

Мэдээдллийг олон нийтэд хүргэхдээ маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэн доорхи үе шатуудаар дараалан арга хэмжээ авна.

- *Хэвлэлийн бага хурал Монголын Хөрөнгийн бирж ХК-тай хамтран хийнэ*
- *Хөрөнгийн биржийн мэдээллийн албатай хамтран ажиллах,*
- *Өдөр тутмын сонины сэтгүүлд мэдээлэл тавих*
- *БиДиСЕК ХК-ийн вэб сайтанд баннар байршуулах*
- *Хувьцааны танилцуулга, брошур бэлдэн танилцуулах,*
- *Гадаадын хөрөнгө оруулагчдад
 - ◆ *Англи хэл дээр тусгай presentation болон танилцуулга брошур бэлдэн танилцуулах,**

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 7.3, 7.4-Д ЗААСАН МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа хаяг:

*Хөх ган ХХК,
Улаанбаатар хот ХУД 1-р хороо Чингисийн өргөн чөлөө “Нэхээсгүй эдлэл” ХК –
ийн байр*

2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар:

Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргав.

3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшдэг этгээдийн талаарх мэдээлэл:

#	Компанийн нэр	Эзэмшиж буй хувьцааны %
1	Бэрэн групп ХХК	75%
2	Фабер инвестмент ХХК	25%

4. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг эзэмшдэг бол түүний хувь хэмжээ:

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан уг үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг эзэмшдэггүй.

5. Үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан санхүүгийн тайлан, өр, зээлийн талаархи мэдээ:

Санхүүгийн үзүүлэлтүүд

Компанийн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлангуудын хураангуйг доорхи хүснэгтэд харуулав.

Хүснэгт

Балансын зүйл	Үлдэгдэл	
	2007.12.31	2008.03.31
Хөрөнгө		
1. Эргэлтийн хөрөнгийн дүн		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19,725,138.70	8,377,166.27
Дансны авлага	1,182,716,040.00	4,030,317.00
Бусад авлага	23,688,118.00	
Бараа материал	34,136,368.92	54,798,348.68
Урьдчилж төлсөн зардал	168,830,866.25	47,632,072.75
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,429,096,531.87	114,837,904.70
2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	178,051,775.00	4,693,213,070.21
Дуусаагүй барилга	1,085,413,854.73	1,891,958,789.25
Бусад үндсэн хөрөнгө		392,218,875.68
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,263,465,629.73	6,977,390,735.14
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,692,562,161.60	7,092,228,639.84
Б.Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
1.Өр төлбөрийн дүн		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	943,715,515.40	
Урт хугацаат өр төлбөр		
Үүнээс банкны хугацаа хэтэрсэн өр		
Өр төлбөрийн дүн	943,715,515.40	0
2. Эзэмшигчдийн өмч		
төрийн		
хувийн	1,747,500,000.00	6,284,337,059.12
Дахин үнэлгээний зөрүү		806,544,934.52
хуримтлагдсан ашиг	1,346,646.20	1,346,646.20
Тайлангийн үе	1,346,646.20	
Өмнөх үеийн		1,346,646.20
Эзэмшигчдийн өмчийн дүн	1,748,846,646.20	7,092,228,639.84
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	2,692,562,161.60	7,092,228,639.84

2007 оны эцсээс 2008 оны 1 дүгээр улирлыг хүртэлх хугацаанд нийт хөрөнгийн хэмжээ 37,96% өсчээ. 2007 оны эцсээр Хөх ган ХХК нь Бэрэн групп ХХК-д 943,7 сая төгрөгийн өр төлбөртэй гэж балансад тусгагдсан ба үүнийг 2008 оны 1 дүгээр улирлын тайланд Бэрэн групп ХХК-ээс Хөх ган ХХК-д оруулсан хөрөнгө оруулалт гэж бүртгэсэн билээ. 2008 оны 1 дүгээр улирлын байдлаар Хөх ган ХХК нь ямар нэгэн өр төлбөргүй байна.

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	2007.12.31	2008.03.31
1. Борлуулалтын орлого		

2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3. Нийт ашиг		0
4. Үндсэн үйл ажиллагааны зардал		
5. Үйл ажиллагааны ашиг		
6. Үйл ажиллагааны бус орлого	1,346,646.20	0
7. Үйл ажиллагааны бус зардал		
8. Татвар төлөхийн өмнөх ашиг	1,346,646.20	0
9. Орлогын татвар		
10. Цэвэр ашиг	1,346,646.20	0

2007 оноос ангижруулсан төмөрлөгийн үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа ба 2008 оны 12 сараас эхлэн үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллан бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхэлнэ.

2007 оноос төсөл хэрэгжүүлэхээр ажилласан ба жилийн эцсийн 1,3 сая төгрөгийн ашиг нь банкны хүүгийн орлого болно.

6. Үнэт цаасыг арилжаалахад зуучлах мэргэжлийн байгууллагын тухай мэдээлэл:

Компани анх 1991 онд Төв аймгийн иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх зорилгоор Баяндөхөм брокерын нүүс нэртэйгээр анх байгуулагдсан. 1995 онд Хөрөнгийн зах зээлд брокер дилерийн иж бүрэн үйл ажиллагаа явуулахаар “БиДиСЕК” ХХК болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

- 1997 онд Улаанбаатар хотод анх салбараа нээж, 1998 онд компанийн төвийг Улаанбаатар хотод шилжүүлсэн.
- МХБ-ийн шалгуур үзүүлэлтээр 2002, 2004, 2005 онуудад тэргүүний үнэт цаасны компани, 2003 онд дэд байрын шагналт үнэт цаасны компаниар шалгарсан.

“БиДиСЕК” ХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь

- Брокер Дилерийн үйл ажиллагаа
- Андеррайтерын үйл ажиллагаа
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа

“БиДиСЕК” ХХК нь 2006 онд компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчлөн “БиДиСЕК” ХК болж хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжаалсан.

“БиДиСЕК” ХК нь 2005 оноос хойш дараах үнэт цаасны андеррайтераар ажилласан байна.

Хувьцаа:


- Женко Тур Бюро ХК
- Монинжбар ХК
- Хай Би Ойл ХК
- Туул Сонгино усны нөөц ХК
- БиДиСЕК ХК

Бонд:


- Монинжбар ХК-ийн Бүтээн байгуулалт бонд
- Пума ХХК-ийн Пума бонд
- Нийслэл өргөө ХК-ийн Нийслэл өргөө бонд

БиДиСЕК ХК 2007 онд МХБ-ийн нийт арилжааны 52,5%-ийг дангаар хийж гүйцэтгэсэн байна. 2000 оноос хойш арилжаанд оролцсон байдлыг графикаар харуулав.

Хувьцааны арилжаа




Компанийн бондын арилжаа



Мянган төгрөгөөр

Засгийн газрын бондын арилжаа



сая төгрөгөөр